



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/231

Ховд

Зарим байгууллага, аж ахуйн нэгжийн
үйл ажиллагааг нээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29.1.6 "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаал, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын шинэ голомт, тохиолдол сүүлийн долоо хоногт бүртгэгдээгүй, батлагдсан тохиолдлын 98 хувь нь эдгэрсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал /улбар шар/-ын 2 дугаар зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын 2 дугаар зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хязгаарлах үйл ажиллагааг хавсралтаар баталж, хязгаарласнаас бусад үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 33 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн нээж ажиллуулсугай

3. Агаар сэлгэлт, халдваргүйтгэлийг 2 цаг тутамд хийх, ажилчид болон үйлчлүүлж байгаа иргэдийн халууныг шалгах, гар ариутгах, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, хүн хоорондын зайг баримталж, мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмж, шаардлагыг мөрдөж ажиллахыг үйл ажиллагаа нь нээгдэж буй иргэн, хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/231 Ch
20 1303



ХЯЗГААРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Жагсаал цуглаан
2. Хурал
3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
4. Соёл урлагийн арга хэмжээ
5. Уралдаан тэмцээн
6. Үзвэр үйлчилгээ
7. Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ
8. Аялал зугаалга
9. Хурим найр, цайллага, хүлээн авалт
10. Шашны зан үйл, сүм хийд мөргөлийн газрын үйл ажиллагаа
11. Нийтийн бүжиг, бүжгийн клуб
12. Бүх төрлийн баар, цахим ба автомат тоглоомын газар,
бүх төрлийн тоглоомын төв

-oOo-